



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
ЭМ, ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АЛБА

Шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн судалгаа

УЛААНБААТАР ХОТ

2018 он

НЭГ. АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ

Эрүүл мэндийн салбарт эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл ихээхэн хийгдэн шинэ дэвшилтэт техник, технологи хурдацтай нэвтэрч байгаагийн хэрээр оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжүүдийн бүтэц, зохион байгуулалт улам бүр нарийсаж байгаа тул эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай үйл ажиллагааг ханган ажиллах шаардлага тулгарч байна.

Өнөөдрийн байдлаар эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалтыг оновчтой бус, засвар үйлчилгээний нэгдсэн зохицуулалт, засвар үйлчилгээнд шаардлагатай сэлбэг, хугацаат сэлбэг хэрэгслийн нөөц түүнд шаардлагатай санхүүжилт хангалтгүй, төсвийн зардлын зүйл ангид тусгагддаггүй тул тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг сайжруулах, хэвийн найдвартай үйл ажиллагаа алдагдахад хүрээд байна.

Иймээс эрүүл мэндийн байгууллагуудад ашигладаг эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд шаардлагатай сэлбэг хэрэгсэл, өндөр өртөгтэй тоног төхөөрөмжийн зайлшгүй солих шаардлагатай хугацаат сэлбэг хэрэгслийн хэрэгцээ судалгаа, түүнд шаардлагатай санхүүжилтийг тодорхойлж, шийдвэр гаргагчдыг үнэн зөв бодит мэдээллээр хангаж, 2019 оны эрүүл мэндийн байгууллагын төсөвт тусгуулах хэрэгцээ шаардлагын дагуу судалгааг хийж байна.

Зорилго:

Эрүүл мэндийн салбарт ашиглагдаж буй эмнэлгийн тоног төхөөрөмжид шаардлагатай сэлбэг хэрэгслийн судалгааг авч нэгдсэн дүнг гаргах.

Зорилт:

1. Эрүүл мэндийн салбарын 2019 онд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгаа хийх.
2. Эрүүл мэндийн байгууллагуудад ашиглагдаж буй эмнэлгийн тоног төхөөрөмжид шаардлагатай сэлбэг хэрэгслийн судалгаа хийх.
3. Шаардлагатай сэлбэг хэрэгслийн хөрөнгө оруулалтын тооцоолол хийж тодорхойлох.

Үр дүн:

Эрүүл мэндийн байгууллагад нэн шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, эрүүл мэндийн байгууллагад ашиглаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжид шаардлагатай сэлбэг хэрэгсэл, хугацаат сэлбэг хэрэгслийн жагсаалт, нөөц бүрдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн тооцоолол гарна.

ХОЁР. ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН СЭЛБЭГ ХЭРЭГСЛИЙН СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2.1. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгслийн судалгааны асуудал ба таамаглал:

Нэн шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгслийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, шаардлагатай санхүүжилтийн тооцоолол бий болсноор тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах нөхцөл боломж бүрдэнэ.

2.2. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгслийн судалгааны арга зүй ба хамрах хүрээ:

Судалгааны арга:

Судалгааг тусгайлан бэлтгэсэн маягтын дагуу мэдээлэл цуглуулж, зарим баримт материалтай танилцан баталгаажуулна.

Судалгааны хамрах хүрээ:

- Эрүүл мэндийн яамны харъяа эмнэлэг, төвүүд
- Нийслэлийн эрүүл мэндийн газрын харъяа эмнэлгүүд
- Бүсийн оношилгоо эмчилгээний төвүүд
- Аймгийн нэгдсэн эмнэлэг
- Сум дундын эмнэлэг
- Сумын эмнэлэг
- Өрхийн эмнэлэг

Хугацаа: 2018 оны 05 дүгээр сарын 28-наас 6 сарын 13-ны хооронд гүйцэтгэнэ.

2.3. Судалгааны хүн хүчин:

- Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба
- Эрүүл мэндийн байгууллагын инженер, техникийн ажилтнууд

2.4. Мэдээлэл цуглуулах:

- Судалгааны удирдамж болон маягтын хамт ЭМЯ-ны болон НЭМГ-ын харьяа, аймгийн эрүүл мэндийн байгууллагад Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс албан бичгээр тус тус хүргэх.
- Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын инженер техникийн алба болон эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтнүүд нь тусгайлан боловсруулсан асуумжийг /Microsoft Office Excel/ бөглөн, цахим шуудангаар илгээх.
- Шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн асуумжийг бөглөхдөө нэн шаардлагатайгаас эхэлж эрэмбэлж ирүүлэх.
- Аймгийн болон нийслэлийн эрүүл мэндийн газар нь харьяа байгууллагуудын мэдээллийг нэгтгэн ирүүлэх.

- Эрүүл мэндийн байгууллагуудад бүртгэлтэй эмнэлгийн тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийхэд шаардлагатай сэлбэг хэрэгсэл мөн хугацаат сэлбэг хэрэгслийг асуумжийн дагуу бөглөх.

2.5. Судалгааны мэдээлэл боловсруулах:

Судалгааны асуумжийн дагуу дүн шинжилгээ хийх ба боловсруулалтын явцад тодорхой бус мэдээллийг цахимаар болон утсаар, биечлэн очиж тодруулга хийж, тайлан бичнэ.

Асуумжийг Microsoft Office Excel программыг ашиглан үр дүнг боловсруулна

ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН СЭЛБЭГ ХЭРЭГСЛИЙН СУДАЛГАА СУДАЛГААНЫ АСУУМЖ

1. 2019 ОНД ШААРДЛАГАТАЙ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ

Эмнэлгийн нэр:

Хүснэгт 1

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Тайлбар
1				
2				
3				
Нийт				

2. 2019 ОНД ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНД ШААРДЛАГАТАЙ СЭЛБЭГ ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

Эмнэлгийн нэр:

Хүснэгт 2

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Үйлдвэрлэсэн улс, үйлдвэрлэгчийн нэр	Сэлбэг хэрэгслийн нэр төрөл, марк	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ
1						
2						
3						
Нийт						

3. 2019 ОНД ШААРДЛАГАТАЙ ӨРТӨГ ӨНДӨРТЭЙ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХУГАЦААТ СЭЛБЭГ ХЭРЭГСЛИЙН ЗАРДЛЫН ЖАГСААЛТ

Эмнэлгийн нэр:

Хүснэгт 3

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Үйлдвэрлэсэн улс, үйлдвэрлэгчийн нэр	Сэлбэг хэрэгслийн нэр марк	Сэлбэг солих хугацаа	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ
1							
2							
3							
Нийт							

ГУРАВ. ҮР ДҮН

Өнөөдрийн байдлаар эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалтыг оновчтой бус, засвар үйлчилгээний нэгдсэн зохицуулалт, засвар үйлчилгээнд шаардлагатай сэлбэг, хугацаат сэлбэг хэрэгслийн нөөц түүнд шаардлагатай санхүүжилт хангалтгүй, төсвийн зардлын зүйл ангид тусгагддаггүй тул тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг сайжруулах, хэвийн найдвартай үйл ажиллагаа алдагдахад хүрээд байна.

Иймээс эрүүл мэндийн байгууллагуудад ашигладаг эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд шаардлагатай сэлбэг хэрэгсэл, өндөр өртөгтэй тоног төхөөрөмжийн зайлшгүй солих шаардлагатай хугацаат сэлбэг хэрэгслийн хэрэгцээ судалгаа, түүнд шаардлагатай санхүүжилтийг тодорхойлж, шийдвэр гаргагчдыг үнэн зөв бодит мэдээллээр хангаж, 2019 оны эрүүл мэндийн байгууллагын төсөвт тусгуулах хэрэгцээ шаардлагын үүднээс энэхүү судалгааг хийлээ. Энэхүү судалгааг 2018 оны 05 сарын 28-ны өдрийн 628 тоот албан бичгээр эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн.

Судалгаанд ЭМЯ-ны харъяа байгууллагууд, НЭМГ-ын харъяа байгууллагууд, 21 аймгийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, сум, сум дундын эмнэлэг өрхийн эрүүл мэндийн төвүүд хамрагдсан. Судалгааны удирдамжийн дагуу аймгийн болон нийслэлийн эрүүл мэндийн газар нь харъяа байгууллагуудын мэдээллийг нэгтгэн ирүүлсэн.

Судалгаанд хамрагдсан байгууллага

Д/д	Байгууллагын ангилал	Тоо ширхэг
1	Клиникийн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн төв	15
2	Нийслэлийн эрүүл мэндийн газрын харъяа байгууллагууд	12
3	Амаржих газар	3
4	Аймгийн нэгдсэн эмнэлэг	14
5	Сумын эмнэлэг, эрүүл мэндийн төв	148
6	Өрхийн эрүүл мэндийн төв	24
7	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	5
Нийт		221

Судалгаанд хамрагдсан шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн тоо ширхэг

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн /тоо ширхэг/
1	Эрүүл мэндийн хөгжлийн төв	33
2	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	
3	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	205
4	Улсын гуравдугаар төв эмнэлэг	168
5	Халдварт өвчин судлалын үндэсний төв	959
6	Гэмтэл согог судлалын үндэсний төв	54
7	Хавдар судлалын үндэсний төв	369
8	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	499
9	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	0
10	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	1
11	<u>Арьсны өвчин судлалын үндэсний төв</u>	17
12	<u>Зоонозын өвчин судлалын үндэсний төв</u>	17
13	<u>Геронтологийн үндэсний төв</u>	20
14	<u>Эмгэг судлалын үндэсний төв</u>	27
15	<u>Хүүхдийн төв сувилал</u>	56
16	Нийслэлийн эрүүл мэндийн газар	2073
17	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	28
18	Архангай аймаг	538
19	Баян-Өлгий аймаг	343
20	Баянхонгор аймаг	193
21	Булган аймаг	29
22	Говь-Алтай аймаг	85
23	Говьсүмбэр аймаг	120
24	Дархан-Уул аймаг	228
25	Дорноговь аймаг	394
26	Дорнод аймаг	301
27	Дундговь аймаг	115
28	Завхан аймаг	286
29	Орхон аймаг	129
30	Өвөрхангай аймаг	208
31	Өмнөговь аймаг	176
32	Сэлэнгэ аймаг	216
33	Сүхбаатар аймаг	152
34	Төв аймаг	235
35	Увс аймаг	130
36	Ховд аймаг	397
37	Хөвсгөл аймаг	704
38	Хэнтий аймаг	185
	НИЙТ	9690

Эрүүл мэндийн байгууллагад 2019 онд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, хугацаат сэлбэг хэрэгсэл болон засвар үйлчилгээнд шаардлагатай сэлбэг хэрэгслийн төсөв

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж /төгрөг/	Засвар үйлчилгээнд шаардлагатай сэлбэг хэрэгсэл /төгрөг/	Өндөр өртөгтэй эмнэлгийн тоног төхөөрөмжийн хугацаат сэлбэг хэрэгсэл /төгрөг/	Нийт дүн /төгрөг/
1	ЭМХТ	315,500,000	23,300,000	43,073,200	381,873,200
2	УНТЭ				-

3	УХТЭ	4,419,700,000			4,419,700,000
4	ШУГТЭ	9,572,900,000	1,322,246,940	950,071,000	11,845,217,940
5	ЭХЭМҮТ	5,143,915,000	377,412,000	353,857,926	5,875,184,926
6	ХӨСҮТ	3,593,000,000	160,413,000	108,650,000	3,862,063,000
7	ГССҮТ	2,903,900,000	4,518,000	31,097,000	2,939,515,000
8	ХСҮТ	3,705,896,300	97,418,750	97,348,750	3,900,663,800
9	СЭМҮТ	215,000,000	10,389,000		225,389,000
10	АӨСҮТ	564,100,000	299,700,000	-	863,800,000
11	ЗӨСҮТ	143,000,000	3,500,000		146,500,000
12	ЦССҮТ		42,840,000		42,840,000
13	ЭСҮТ	448,893,000	8,325,000	31,100,000	488,318,000
14	ГҮС	457,702,600	350,000	-	458,052,600
15	ХТС	65,901,000	4,310,000		70,211,000
16	НЭМҮТ	404,367,900	33,778,204	71,500,000	509,646,104
17	НЭМГ	18,900,149,500	340,818,939	703,848,000	19,944,816,439
18	Архангай аймаг	2,708,910,000	41,710,000	46,576,000	2,797,196,000
19	Баянхонгор аймаг	550,353,956	300,793,043	13,710,000	864,856,999
20	Булган аймаг	130,500,000	14,800,000		145,300,000
21	Баян-Өлгий аймаг	2,254,877,192	129,375,118		2,384,252,310
22	Говь-Алтай аймаг	471,100,000	83,600,000	17,240,000	571,940,000
23	Говьсүмбэр аймаг	368,633,226	64,000,000	6,581,500	439,214,726
24	Дархан-Уул аймаг	1,681,580,000	30,927,310	8,868,000	1,721,375,310
25	Дорнод аймаг	2,662,272,100	33,870,000	129,111,450	2,825,253,550
26	Дорноговь аймаг	2,048,568,107	57,500,000	11,007,500	2,117,075,607
27	Дундговь аймаг	2,208,894,000	10,900,000	3,105,000	2,222,899,000
28	Завхан аймаг	2,052,580,375			2,052,580,375
29	Орхон аймаг	1,962,290,804	24,286,204	1,840,000	1,988,417,008
30	Өвөрхангай аймаг	2,362,205,000	276,500,000	18,608,000	2,657,313,000
31	Өмнөговь аймаг	990,840,000		15,620,000	1,006,460,000
32	Сүхбаатар аймаг	1,377,647,000	223,826,560	103,168,388	1,704,641,948
33	Сэлэнгэ аймаг	335,183,000		5,098,000	340,281,000
34	Төв аймаг	6,881,742,171	34,998,500	141,275,295	7,058,015,966
35	Увс аймаг	1,216,457,000	16,650,000	120,990,834	1,354,097,834
36	Хэнтий аймаг	2,020,230,000	24,172,930	18,922,930	2,063,325,860
37	Ховд аймаг	867,900,000	4,220,000	86,697,300	958,817,300
38	Хөвсгөл аймаг	4,162,357,944	3,405,000	18,474,000	4,184,236,944


НИЙТ	90,169,047,175	4,086,584,498	3,157,440,073	97,413,071,746
-------------	-----------------------	----------------------	----------------------	-----------------------



Аймгийн эрүүл мэндийн байгууллагын шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, засвар үйлчилгээнд шаардлагатай сэлбэг, хугацаат сэлбэг хэрэгслийн төсөвт БОЭТ, нэгдсэн эмнэлэг, сумын эмнэлэг, эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвийн судалгааг нэгтгэн оруулсан болно.



Нийт 97,431,071,746 төгрөгийн 90,169,047,175 төгрөг нь шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, 4,086,584,498 төгрөг нь засвар үйлчилгээнд шаардлагатай сэлбэг хэрэгсэл, 3,157,440,073 төгрөг нь хугацаат сэлбэг хэрэгсэл авахад шаардлагатай байна.



Дүгнэлт

Эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд шаардлагатай сэлбэг хэрэгсэл, өндөр өртөгтэй тоног төхөөрөмжийн зайлшгүй солих шаардлагатай хугацаат сэлбэг хэрэгслийн хэрэгцээ судалгаа, түүнд шаардлагатай санхүүжилтийг тодорхойлж, шийдвэр гаргагчдыг үнэн зөв бодит мэдээллээр хангах, 2019 оны эрүүл мэндийн байгууллагын төсөвт тусгуулах хэрэгцээ шаардлагын үүднээс энэхүү судалгааг хийлээ. Энэхүү судалгааг 2018 оны 05 сарын 28-ны өдрийн 628 тоот албан бичгээр эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн.

Шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, хугацаат болон засвар үйлчилгээнд шаардлагатай сэлбэг хэрэгслийн судалгааг клиникийн болон нарийн мэргэжлийн төв 15, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл 7, дүүргийн нэгдсэн эмнэлэг 3, амаржих газар 3, тосгоны эрүүл мэндийн төв 2, аймгийн нэгдсэн эмнэлэг 14, бүсийн оношилгоо эмчилгээний 5, өрхийн эрүүл мэндийн төв 24, сумын эмнэлэг, эрүүл мэндийн төв 148 нийт 221 эрүүл мэндийн байгууллага судалгааг ирүүлсэн бөгөөд судалгаагаар шаардлагатай 9690 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмжийг ирүүлсэн.

- Судалгааг ирүүлсэн эрүүл мэндийн байгууллагуудаас Улсын гуравдугаар төв эмнэлэг хамгийн их буюу 11,845,217,940 төгрөгийн төсөв ирүүлсэн. Энэхүү төсөвт оношилгооны дурангийн ком, флюоресцентэнд ажилладаг мэдрэлийн мэс

заслын хагалгааны микроскоп, дижитал рентген зураг авалтын аппарат, PCR машин зэрэг өндөр үнэ бүхий аппаратууд мөн ангиографийн аппарат, компьютер томографын засвар үйлчилгээний гэрээний төсөв ирүүлсэн. Мөн Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв зэрэг байгууллагууд нь Соронзон резонанст томографын аппарат, Компьютер томограф, Ангиографийн аппарат зэрэг өндөр үнэ бүхий аппаратуудын төсвийг ирүүлсэн.

- Аймгуудаас Төв, Хөвсгөл аймаг хамгийн их төсөв ирүүлсэн. Энэхүү төсөвт Соронзон резонанст томографын аппарат, Компьютер томограф, Ангиографийн аппарат, Флюорографийн аппарат мөн Хөвсгөл аймгаас хамгийн олон буюу 21 сумын эрүүл мэндийн төвөөс судалгааг ирүүлсэн.
- 221 эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн 2019 онд шаардлагатай 90,169,047,175 төгрөгийн өртөг бүхий 9690 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийг авч нэгтгэсэн.
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн 4,086,584,498 төгрөгийн өртөг бүхий засвар үйлчилгээ хийж гүйцэтгэхэд шаардлагатай сэлбэг хэрэгслийн жагсаалтыг авч нэгтгэсэн.
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн 3,157,440,073 төгрөгийн өртөг бүхий хугацаат сэлбэг хэрэгслийн жагсаалтыг авч нэгтгэсэн.
- Дээрх эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн судалгаанаас үзэхэд Эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ болон хугацаат сэлбэг хэрэгслийн зардалд нийт 97,413,071,746 төгрөгийн төсөв шаардлагатай байна.

Тайлан хянасан:Ш.Энхзаяа /ЭЭТТА-ны дарга/

Тайлан боловсруулсан:..... Б.Санж-Очир /ЭЭТТА-ны мэргэжилтэн/